УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН ТУШААЛ

2022 оны 06 сарын 08 өдөр Дугаар А/91 Улаанбаатар хот

Үнэлгээний хороо байгуулах тухай

Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.6, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 46 дугаар зүйлийн 46.1.1, 47 дугаар зүйлийн 47.1, Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын "Нийслэлийн 2022 оны төсөв батлах тухай" 11/34 дугаар тогтоол, Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.2, 3 дугаар зүйлийн 3.1.10-т заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Нийслэлийн Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын "Нийслэлийн 2022 оны төсөв батлах тухай" 11/34 дугаар тогтоолын 3.2.1.2-д заасан хот нийтийн тохижилт үйлчилгээний зардалын батлагдсан хот нийтийн аж ахуйн тохижилт үйлчилгээний 2022 оны төсвийн зардлын задаргаа ажлын жагсаалтын 3.5, 3.7 дүгээрт заасан ажлын гүйцэтгэгчийг тус тус сонгон шалгаруулах Үнэлгээний хороог дараах бүрэлдэхүүнтэйгээр байгуулсугай.

Дарга:	Д.Ганбат	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Захиргаа, санхүүгийн хэлтсийн мэргэжилтэн
Гишүүд	Д.Нааяа	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Хотын инженерийн байгууламжийн хэлтсийн мэргэжилтэн
	Ц.Дарханбат	Тактижент төрийн бус байгууллагын гишүүн
	М.Оргил	Сэтгэл зүй, судалгаа, мэдээллийн төв нийгэмд үйлчлэх Төрийн бус байгууллагын тэргүүн
Нарийн бичгийн дарга	Б.Мөнхжаргал	Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны Орчны бохирдол, хог хаягдалын удирдлагын хэлтсийн мэргэжилтэн

C:\Users\User\Desktop\ҮЖ 12\doc 2022\тушаал.docx

1110300535

2. Тендерийн баримт бичгийг боловсруулж батлуулан, гүйцэтгэгчийг сонгон шалгаруулах ажиллагааг холбогдох хууль, журмын дагуу зохион байгуулахыг Үнэлгээний хороо (Д.Ганбат)-нд даалгасугай.

3. Худалдан авах ажиллагаатай холбоотой бүх баримт бичгээр хадгаламжийн нэгж үүсгэн архивт хүлээлгэн өгөхийг Үнэлгээний хорооны нарийн бичгийн дарга (Б.Мөнхжаргал) -д үүрэг болгосугай.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГЫН АЛБАН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН
ГҮЙЦЭТГЭГЧ Д.ГАНБОЛД